

**“Хай Би Ойл” ХК-ийн 2018 оны жилийн  
үйл ажиллагааны тайлан**

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: (+976) – 9909 8989, 9116 7117%

Улсын бүртгэлийн мэдээлэл:	№ 9010001063,
Регистрын дугаар	№ 2615134
Үйл ажиллагааны чиглэл:	Техникийн тосны үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа
Үнэт цаасны тоо ширхэг:	52,118,954 ширхэг

**Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд: Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:**

Өмнөх оны тосны үлдэгдэл түүхий эдийн нөөц 72’039 литр, боловсруулсан тос /Мазут/ 36’035 литр байсан ба 2018 он гарснаас хойш тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК нь нийт 295’059л буюу 94’554’440 төгрөгийн түүхий эдийг байгууллага болон хувь хүнээс цуглуулсан байна. Үүнээс 314’647л мазут боловсруулан авч 5 аж ахуйн нэгжид 229’423’050 төгрөгийн үнэ бүхий 267’553л мазутыг борлуулсан байна. Дээрх тоон үзүүлэлтүүдийн задаргааг харуулбал:

Түүхий эд материал:

Нэр	Нэгж	2017 оны үлдэгдэл	2018 оны хагас жилд
Түүхий эд буюу ажилласан масло	литр	72’039	295’059
<b>Нийт</b>	литр		<b>295’059</b>

Борлуулалт:

№	Худалдан авсан байгууллагын нэр	Хэмжээ	НӨАТ орсон үнэ /төгрөг/	
			Нэгж үнэ	Нийт үнэ
1	“МБИндустрал” ХХК	203’156 л	850	172’682’600
2	“УВТ инвест” ХХК	239,020 л	900	215’118’000
3	“Наранбулаг хан” ХХК	236’353 л	850	200’899’965
4	“Дэвжих-Эрдэнэ” ХХК	108’000 л	850	91’800’000
5	“Эко асфальт” ХХК	18’089 л	831.2	15’035’650
6	“Монстрой инженеринг” ХХК	21’600 л	770	16’632’000
7	“Нефть проект” ХХК	376’800 л	820	308’976’000
8	“Ялгуусан” ХХК	5’400 л	850	4’590’000
<b>Бүгд дүн</b>		<b>1’288’758 л</b>		<b>1’025’734’215</b>

**Гэрээ хэлцэлүүд болон томоохон худалдан авагчид:**

2018 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 1 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 6 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 10 гэрээнүүдийг тус бүр байгуулсан байна. 2018 онд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:


№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Эхлэх	Дуусах	Гэрээний үнэ
Түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой					
1	“Далайван Аудит” ХХК	Аудитын ажил гүйцэтгэх	2018/03/30	2018/04/27	15’500’000₮
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ					
1	“И Эйч Эс Эм” ХХК	ГТБ, ЧУХБаталгаа ажил гүйцэтгэх	2018/01/05	2018/02/06	2’000’000₮
2	Эрчим хүч, ус хангамжийн I анги	Цахилгаан эрчим хүчээр хангах	2018/02/06	2020/02/06	Хэрэглээгээр сар бүр төлөх
3	СХД-ийн татвар болон Тээвэрлэлт Үйлчилгээний Төв	ХХҮХураамж, тээвэрлэх гэрээ	2018/04/25	2018/12/31	Нэг рейс бүр 60’000₮
4	“Кевико” ХХК	Интернэт хурдыг нэмэгдүүлэх	2018/05/01	---	135’000₮ сар бүр төлөх
5	Иргэн Г.Хишигт	ЦТП, трансф.-ын засварын гэрээ	2018/06/25	2018/07/01	751’500₮
6	Иргэн Т.Гансүх	Газар шорооны ажлын гэрээ	2018/07/21	2018/07/28	5’500’000₮
7	СХД, ЗДТГазар	Ус ашиглах гэрээ	2018/07/30	---	Хэрэглээгээр 12/05-нд төлнө
7	Иргэн Г.Бямбадоо	Тос халаагч тогоо хийх ажил	2018/11/30	2019/03/01	26’054’875₮
Худалдах, худалдан авах гэрээ					
1	“Наранбулаг хан” ХХК	Мазут худалдах	2018/04/10	2019/04/10	170’000’000₮
2	“УВТ Инвест” ХХК	Мазут худалдах	2018/05/01	2019/05/01	360’000’000₮
3	“Петроплас” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/05/22	2018/07/01	5’000’000₮
4	“Нефть Проект” ХХК	Мазут худалдах	2018/08/01	2018/11/01	820’000₮/тн , 250’000₮/рейс.
5	“Гранд сутаг” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/08/30	2019/08/30	Газар дээрээс нь очиж авах
6	“Акалико ресорс” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/08/30	2019/08/30	Газар дээрээс нь очиж авах
7	“Эрч гранд” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/08/30	2019/08/30	Газар дээрээс нь очиж авах
8	Иргэн В.Уртнасан	Өтгөн тос худалдан авах	2018/09/17	2019/09/17	Газар дээрээс нь очиж авах
9	“Петроплас” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/11/01	2019/01/01	11’986’400₮
10	“Ви Икс Моторс” ХХК	Ажиллсан масло худалдан авах	2018/11/05	2019/11/05	Газар дээрээс нь очиж авах

“Хог хаягдлын тухай хууль” энэ оны эхэн сард шинэчлэгдэн батлагдснаар Аюултай хог хаягдал (үүнд: техникийн хаягдал тос орж байгаа) үүсгэгч болон дахин боловсруулах үйлдвэр, ААН-д улсын хэмжээнд хяналт шалгалт эрчимтэй хийгдэж, жил бүр Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Байгаль Орчны хэлтэсээс Улаанбаатар хот орчмын авто техникийн засвар үйлчилгээний төвүүд, техникийн хаягдал тос гарах бүхий л байгууллага, ААН-д хуулийн заалтын дагуу үйл ажиллагаа явагдаж буй эсэхэд хяналт шалгалт явагдснаар манай байгууллагад түүхий эд нийлүүлэх засвар үйлчилгээний төвүүдийн тоо нэмэгдсэн байгаа. Гэрээлж байгаа засварын үйлчилгээний төвүүдээс ажилласан маслыг бид өөрсдийн унаагаар газар дээрээс нь нэг литр тутмыг 150-270 төгрөгийн хооронд татан авч үйлдвэрт төвлөрүүлэхээр гэрээг хийсэн. Энэ шалгалт нь манай байгууллагад 2018.04.20-ны өдөр явагдсан ба НМХГ-ын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудсаар манай байгууллага нь 24%-ийн бага эрсдэлтэй гэсэн үнэлгээтэйгээр үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх болсон. Дээрх байгаль орчны нөлөөлөх эрсдлийг бууруулахад дараах арга хэмжээг авах шаардлагатай.

1. Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэж, түүний дагуу өгсөн зөвлөмжөөр сөрөг нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах.
2. Орчны агаарын шинжилгээг тогтмол хийлгэж, түүний дагуу үр дүнгээр илэрсэн сөрөг нөлөөлөлийг бууруулж ажиллах.
3. Ус ашиглах эрхийн бичгийг гүйцээж гаргуулах.
4. Гадаад, дотоод орчны цэвэрлэгээ хариуцсан нэгж, ажилтантай байх.
5. Байгаль орчны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулж, түүгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх гэсэн санал, шаардлагыг тавьсан байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, гамшиг эрсдэлийн үнэлгээний тайланг хийлгэхэд Байгаль Орчны Яамнаас компанийн байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулан авч, СХД-ийн засаг дарга болоод хорооны иргэдийн хурлаар санал дэмжлэгийг авч үнэлгээнүүдийг хийлгэж дууссан болно. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрийн нутаг дэвсгэрт хамаарах Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс үйлдвэрийн галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулж, Нийслэлийн байгаль орчны газар болоод СХД-ийн засаг даргаас ус ашиглуулах дүгнэлт болоод ус ашиглах эрхийн бичгийг албан ёсоор гаргуулан авч, үйлдвэрийн хашаанд байрлах худгийг гэрчилгээжүүлж улсад бүртгүүлсэн болно. Мөн “И Эйч Эс Эм” ХХК-тай 01/119 тоот “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил” гүйцэтгүүлэх гэрээг хийж, гэрээт ажлыг 100%-ийн гүйцэтгэлтэйгээр хийлгэсэн байна.

Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулсан.



"ХАЙ БИ ОЙЛ" ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 81 71,  
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019.03.16 № 13/1604  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**Ерөнхий үнэлгээний  
дүгнэлт хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулж ирүүлсэн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг 20-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих "Тос цэвэрлэх үйлдвэр"-ийн төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд шинээр батлагдсан аргачлалын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2018 оны 4 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ  Г.НЯМДАВАА

0000117168



БОАЖЯамнаас тос цэвэрлэх үйлдвэрийн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2018-2022 он)

Хянасан БОАЖЯ-ны ерөнхий шинжээч:



/Г. НЯМДАВАА /

**“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн тос цэвэрлэх үйлдвэрийн төслийн  
байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2018-2022 он)**

Боловсруулсан:

“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК-ийн гүйцэтгэх захирал



/С.ХАНДСҮРЭН /

Төсөл хэрэгжүүлэгч:

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн гүйцэтгэх захирал



/Ө.ХҮДРЭЭ /

Улаанбаатар хот

2018 он

ОБЕГазраас Гамшиг эрсдэлийн үнэлгээний тайланг 3 жилийн хугацаатайгаар баталгаажуулан гаргасан.

**Батлав:**

ОБЕГ-ын захиргаа удирдлагын газрын дарга, хурандаа



Л.БОЛДБААТАР

## “ХАЙ БИ ОЙЛ” ХХКОМПАНИЙН АШИГЛАСАН ТОСНЫ ҮЙЛДВЭРИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайланг боловруулсан  
“Тэкол” ХХК-ийн захирал



Г.ТӨМӨРТУЛГА

Тайланг захиалсан  
“Хай Би Ойл” ХХК-ийн  
гүйцэтгэх захирал



Ө.ХҮДРЭЭ

2018 он

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БАЙРЛАХ “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН  
ХАРЪЯА ТОС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТӨЛӨВ  
БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн :



“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК

Гүйцэтгэгч байгууллагын хаяг : БЗД, 1-р хороо, 20/2, 13 тоот


Холбоо барих утасны дугаар : 88010052, 70166858

Факс :

И-мэйл хаяг : [ehsmmongolia@gmail.com](mailto:ehsmmongolia@gmail.com)

Улаанбаатар хот 2018 он






**МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА**  
**БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

**МБ2016/02**

Монгол Улсын Газрын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн “И Эйч Эс Эм” ХХК /РД: 5565421/-д мэргэжлийн байгууллагын эрхийг дараах заалтын дагуу 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 3 жилийн хугацаатай олгов.

1. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх
2. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх

Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

САЙД  З.БАЯНСЭЛЭНГЭ

МУЗГХА, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас “И Эйч Эс Эм” ХХК-ийн хийсэн ажлын дүгнэлтийг баталгаажуулсан тухай албан тоот.



“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 3, Утас: 26 22 70,  
Факс: (976-11) 32 26 83, E-mail: info@gazar.gov.mn

2018.08.30 № 1/1604  
танай 2018.08.28 -ны № 135 -Т

### Дүгнэлт баталгаажуулсан тухай

Монгол Улсын “Газрын тухай хууль”-ийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-ын 3.6-д заасны дагуу “ХАЙ БИ ОЙЛ” ХХК-ийн захиалгаар танай компаний хийж гүйцэтгэсэн нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах газар эзэмших эрхийн 172247 дугаар гэрчилгээтэй газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын дүгнэлтийг баталгаажуулан хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

0801802876

**ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ**

Хянан баталгааны төрөл: Захиалгат Огноо: 2018-08-20

- Газар ашиглагч: "Хай Би Ойл" ХХК
- Аймаг (нийслэл): Улаанбаатар Сум (дүүрэг): Сонгинохайрхан
- Газар ашиглалтын төрөл: Үйлдвэрийн газар
- Байршил: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд Д.Т.Д-С 1270 м-т өндөрт оршино.
- Нэгж талбарын дугаар: 1116-Хай Би Ойл-01  
Хөрсний код: 2201, Нимгэн хүрэн хөрс.  
Бэлчээрийн код: 104\X-1-2-3, Хялгана-шарилжит
- Нийт талбайн хэмжээ: 0.89 га
- Газар ашиглах зориулалт: Хот суурин, барилга байгууламж
- Газар ашиглах, эзэмших шийдвэр: ЗД-ын 2008-05-30 өдрийн 215 тоот шийдвэрээр эзэмших гэрчилгээ, хугацаа 15 жил, гэрчилгээний дугаар 0172247
- Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

№	Талбайн нэр	Талбайн хэмжээ, м2	Үүнээс эвдэрч бохирдсон, талбайн хэмжээ, м2		
			Физикийн	Химийн	Биологийн
	<b>Нийт</b>	<b>8858.65</b>	<b>1140.74</b>	-	-
1	Үйлдвэрийн байр	338.31	338.31	-	-
2	Ажлын байр	45.70	45.70	-	-
3	Агуулах	34.96	34.96	-	-
4	Харуулын байр	36.20	36.20	-	-
5	Худаг	16.36	16.36	-	-
6	Трансформатор	16.61	16.61	-	-
7	Граш	31.53	31.53	-	-
8	Ногоон байгууламж	106.65	106.65	-	-
9	Тосны танкууд	360.33	360.33	-	-
10	Суурь	88.71	88.71	-	-
11	Бетон талбай	65.39	65.39	-	-
12	Сул чөлөөтэй талбай	7717.91	-	-	-

10. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал: Газар ашиглалтын хувьд Бидний судалгааны ажлын хүрээнд 0.89 га талбай хэмжигдсэн байна. Үүнээс 338.31 м2 нь үйлдвэрийн байр, 45.70 м2 нь ажлын байр, 34.96 м2 нь агуулах, 36.20 м2 нь харуулын байр, 16.36 м2 нь гүний худаг, 16.61 м2 нь трансформатор, 31.53 м2 нь граш, 106.65 м2 нь ногоон байгууламж, 360.33 м2 нь тосны агуулах, 88.71 м2 нь суурь, 65.39 м2 нь бетон талбай, 7717.91 м2 нь сул чөлөөтэй талбай байна. Уг үйлдвэрийн хашаа нь бетон хашаагаар хүрээлэгдсэн ба хашаанд оффисийн байр, үйлдвэрийн байр, тосны агуулах, харуулын байр, авто зогсоол зэрэг объект байна. Газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй ба гадна тохижилт сайн. Элдэв химийн болон ахуйн бохирдолт байхгүй.

11. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл: Уг талбайд нимгэн хүрэн хөрс тархах ба хөрсний химийн шинж чанарыг тодорхойлох үүднээс дараахи задлан шинжилгээ хийлгэхэд ялзмаг агууламж бага, өнгөн үе давхаргадаа 1.89 % бөйх ба үржил шимийн хувьд 100 г хөрсөндөө нитрат азот 4.92 мг, хөдөлгөөнт фосфор 1.5 мг, хөдөлгөөнт кали 17 мг юм. Хөрсний хялбар уусах давсны агууламж 0.355 ds/m буюу маш бага ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлөхгүй хэмжээнд байна. Хөрсний урвалын орчин 10.3 буюу их шүлтлэг байна.

Хөрсний агрохими шинж чанар

Дээжний нэр	pH	ЦДЧ, ds/m	Ялзмаг %	Давс, %	NO3	CO2	Сопилцох суурь, мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca+Mg	Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж-1	10.3	0.355	1.89	0.17	4.92	0.82	18.2	9.4	8.8	1.5	17
	10.7	0.288	0.28	0.14	1.99	-	13.4	6.9	6.5	0.8	14
Дээж-2	8	0.087	1.33	0.04	2.92	0.16	9.5	4.8	4.7	0.7	11
	8	0.132	0.82	0.06	3.08	0.99	19.5	10.8	8.7	1	5
	10.1	0.31	0.48	0.15	2.11	0.16	14.2	11.2	3	1	10

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар байна.  
Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1	7.3	65.1	15.4	1.6	10.5	10.1	22.2
	18.9	66.5	11.3	0.0	6.9	6.5	13.3
Дээж 2	6.5	66	16.6	3.6	6.1	1.2	10.9
	4.3	63.8	16.6	2.8	4.4	8.1	15.4
	9.9	61.4	17.8	0.8	5.3	4.8	10.9

Задлан шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх хар тугалга, цайр, хром, кадми, зэс, никель гэх мэт хүнд металлын агууламж MNS 5850:2008 /Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ/ стандарт хэмжээнээс бага гарсан учир хөрс бохирдолгүй гэж үзлээ.

**Хөрсний бохирдлын дүн**

Дээж №, байршил	Хөрсний эрүүл ахуй		Хөрсөн дэх хүнд металлын агууламж, %					
	Колититр	Перфенгинс	Zn	Ni	Cr	Cd	Pb	Cu
Дээж 1	илрээгүй	илрээгүй	35.3	43.5	27.8	0	56.2	8.92
			46.8	50.1	31.6	0	55.8	4.38
Дээж 2	илрээгүй	илрээгүй	27.8	47.6	33.7	0	48.5	6.34
			46.5	44.1	33.0	0	80.7	4.63
			47.0	30.2	34.8	0	84.6	5.31
MNS 5850:2008	MNS 4694:1998	MNS 6340:2003	300	150	150	3	100	100

12. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтол, талхлагдлын хэлбэр: Үйлдвэрийн хашванд ургамлын тор тавьж бичиглэл хийхэд дараахи байдалтай байв. Энд 35-40%-ийн ерөнхий бүрхэцтэй их талхлагдсан хялгана-шарилжит бүлгэмдэл давамгайлж байсан ба 1 м<sup>2</sup> талбайд 5 зүйл, 10 м<sup>2</sup> талбайд 10 зүйл ургамал тааралдана. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд хялгана, шарилж 10-15%-ийн бүрхэцтэй давамгайлж бага бүрхэцтэйгээр үетэн, алаг өвс оролцон ургана. Ургамлын дундаж өндөр 8-10 см, 1 га-ийн зун намрын малд идэгдэх хуурай ургац 2.5 ц байна.

**Ургамлын бүрхэвчийн төлөв байдал**

д/д	Бэлчээрийн төрлийн нэр	Зүйлийн бүрэлдэхүүний тоо (10м <sup>2</sup> талбайд)	1 м <sup>2</sup> талбайд тохиолдох зүйлийн тоо	Ургамлын бүрхэц, %	Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Ургац, ц/га
3	X-I-2-3a /Хялгана-Шарилжит /	10	5	40	Аль, шарилж -15	30	5	2.5

13. Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл: Өндөр хүчдэл, гуу жалга, үерийн ам, гал зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал ноцтой зөрчигдөөгүй.

14. Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээ, өгөх зөвлөмж: Уг үйлдвэр нь 0.89 га талбайг эзэлнэ. Ахуйн болон химийн бохирдолт байхгүй. Газар ашиглалт, гадна тохижилт сайн. Хүн мал амьтны нөлөөллөөс хэмжээн нийт талбайн 1140.74 м<sup>2</sup> нь физикийн эвдрэлд орсон. Цаашид одоогийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр машин болон явган хүний зөм бий болгох, нэгдсэн хогийн цэг, бие зөсөх газар, авто зогсоол зэргийг сайтар шийдэж өгөх ба сул чөлөөтэй талбайд тос асгаж хөрсөнд нэвчүүлэхгүй байх талаас анхаарах хэрэгтэй. Мөн MNS 5850:2008/Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ/, MNS 3297-91, Байгаль хамгаалал, Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ/ стандартуудыг баримтална.


ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД,  
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Д.ГАНХҮҮ



Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах 56 асуулт бүхий хяналтын хуудсаар баримт материалыг шалгуулж компани нь 24%-ийн бага эрсдэлтэй ангилалд багтаж үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхээр болсон.



**№2.23.ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага: *МХХГ, БОГЧУХХ*  
 Шалгуулагч этгээдийн нэр: *Хай - 06 - 013*  
 Объектын нэр: *Халцагч ус дамжуулах үйлдвэр*  
 Регистрийн дугаар: *2615134*

Хяналт шалгалт хийсэн огноо: *2019.04.20*

Шардлага хангасан асуултын тоо:	<b>28</b>	Хууль сахиу мөрдөлтийн хувь:	<b>71</b>		
Шардлага хангаагүй нийт оноо:	<b>28</b>	Эрсдэл үүсэх магадлалын хувь:	<b>24</b>	Эрсдэл үүсэх магадлал	

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо
			Шардлагыг хангасан	Шардлагыг хангаагүй	
1	2	3	4	5	
<b>Байгаль орчинд нөлөөлөх байдал, аудит</b>					
1	БОНБҮТХ 7.1, 7.2, 7.3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй	✓		
2		Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй	0	20	0
3		Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан	0	20	0
4		Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан	0	5	-
5	БОХТХ 9.4, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-05 тоот журам	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан	0	10	-
6		Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан	0	5	-
7		Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан	0	5	0

Хуудас 1

8		Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ	0	5	0
9		Байгаль орчны аудитыг 2 жил тутам хийлгэсэн	0	5	5
10	БОХТХ 10.1	Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу сөрөг нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	0	5	5
<b>Газар ашиглалт</b>					
11	ГТХ 27.1	Газар эзэмших эрхийн хүчин төгөлдөр гэрчилгээ, гэрээтэй	0	10	0
12	КЗГКТХ 16.3, 16.4	Эдлэн газар нь газрын улсын бүртгэлд бүртгэгдсэн	0	5	0
13	ГТХ 58.2	Газрын төлөв байдал, чанарын хянан магадлагаа хийлгэсэн	0	5	0
14	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 MNS 5480:2014 1.2	Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж зүлэгжүүлсэн	0	5	0
15	БОНБҮТХ 9.8 БОНХС-ын 2014.01.06-ны А-05 тушаалаар батлагдсан журам	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орсон ажлуудыг хугацаанд нь бүрэн хийж, холбогдох төрийн байгууллагад тайлангаа хүргүүлж, баталгаажуулсан.	0	10	0
<b>Хөрсний бохирдол</b>					
16	БОНБҮТХ 9.7, БОНХС-ын 2014.01.06-ны А-05 тушаалаар батлагдсан журам	Хөрсний шинжилгээг тогтмол хийлгэдэг	0	5	0
17	БОНБҮТХ-ын 9.6	Хөрсний шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсан	0	10	0
18		Хүнд металлын шинжилгээ стандартын түвшинд байгаа	0	5	-
19	MNS 5850:2008	Хөрсний нянгийн бохирдол стандартын түвшинд байгаа	0	5	-
20		Хөрсний химийн бохирдол стандартын түвшинд байгаа	0	5	-
<b>Бохир ус</b>					
21	БОНБҮТХ-ын 9.7, БОНХС-ын 2014.01.06-ны А-05 тушаалаар батлагдсан журам	Усны шинжилгээг тогтмол хийлгэдэг	0	5	0
22		Хүрээлэн буй орчинд хаягдах бохир усны умбуур бодис 50 мг/л-ээс ихгүй	0	5	-
23		Бохир усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 20 мг/л-ээс ихгүй	0	5	-

24	MNS 4943:2015	Хүрээлэн буй орчинд хаягдах химийн хэрэгцээт хүчилтөрөгч 50 мг/л-ээс ихгүй	0	5	-
25		Хүрээлэн буй орчинд хаягдах бохир усны үлдэгдэл хлор 1 мг/л-ээс ихгүй	0	5	-
26		Хүрээлэн буй орчинд хаягдах бохир усны хаягдал усны pH 6-9 хооронд	0	5	-
27	БОНБУТХ-ын 9.6	Бохир усны шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсан	0	10	-
<b>Агаарын бохирдол</b>					
28	БОНБУТХ-ын 9.7, БОНХС-ын 2014.01.06-ны А-05 тушаалаар батлагдсан журам	Орчны агаарын шинжилгээг тогтмол хийлгэдэг	0	5	5
29		PM <sub>2,5</sub> нарийн ширхэглэлт тоосонцор 50 мкг/м <sup>3</sup> /24 цагийн дундаж/ хэтрээгүй	0	5	
30		PM <sub>10</sub> том ширхэглэлт тоосонцор 100 мкг/м <sup>3</sup> /24 цагийн дундаж/ хэтрээгүй	0	5	
31	"Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016	Нийт тоосонцор 500 мкг/м <sup>3</sup> , /20 минутын дундаж/ хэтрээгүй	0	5	
32		Хүхэрлэг хий SO <sub>2</sub> , 450 мкг/м <sup>3</sup> , /20 минутын дундаж/ хэтрээгүй	0	5	
33		Нүүрстөрөгчийн дутуу исэл CO, 60000 мкг/м <sup>3</sup> , /20 минутын дундаж/ хэтрээгүй	0	5	
34		Азотын давхар исэл NO <sub>2</sub> , 200 мкг/м <sup>3</sup> , /20 минутын дундаж/ хэтрээгүй	0	5	
35	БОНБУТХ-ын 9.6	Орчны агаарын шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсан	0	10	10
36	АТХ 13.2	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилладаг /усалгаа, боловсруулсан түлш, цахилгаан ашигладаг, утаа шүүх тоног төхөөрөмж суурилуулсан гэх мэт/	0	10	-
<b>Ус ашиглалт</b>					
37	УТХ 28.1, 28.4	Ус ашиглах дүгнэлттэй	0	10	0
38	УТХ 28.11	Ус ашиглах эрхийн бичигтэй	0	5	5
39	УТХ 30.1.4	Ус авах цэгт тоолуур байрлуулж, баталгаажуулсан	0	3	0
40	УТХ 31.1	Ус ашигласны төлбөр төлсөн	0	3	0
<b>Хог хаягдал</b>					
41	БХТХ 31.3	Байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, арга хэмжээ авсан	0	10	0



42	ХХТХ 10.2.3, 10.2.4	Ахуйн хог хаягдлаа цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллага болон тогтоосон цэгт хүлээлгэн өгдөг	0	5	0
43	ХХТХ 10.2.17, 4.4.3	Хог хаягдлын гэрээ байгуулах, хяналт тавих, гадаад дотоод орчны цэвэрлэгээ хариуцсан нэгж ажилтантай	0	5	5
44	ХХТХ 23.4, 4.4.2	Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэсэн	0	5	0
45	ХХТХ ХХБАБХТАУЖурам 5.5.5 дахь заалт, 23.1.	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад шилжүүлэх хүртэл түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд, хуулийн хугацаанд хадгалсан	0	5	0
46	ХХТХ 10.2.5,	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгдөг	0	5	-
<b>Нөхөн сэргээлт</b>					
47	БОНХАЖ-ын Сайдын 2015.12.16-ны өдрийн А/419 тушаал	Ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж тухайн орон нутагт хүлээлгэж өгсөн ахттай	0	10	-
48	МУ-ын Засгийн газрын 2015.03.30-ны 120 журам 4.5	Өмнө нь задралд орсон болон тухайн жилд задралд орох талбайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулсан.	0	10	
49	БОХТХ 31.2, 31.5	Нөхөн сэргээлт хийсэн тухай улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.	0	10	
50	MNS5917:2008/ MNS5918:2008	Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулсан	0	10	
51	MNS5916:2008	Шимт хөрсийг тусгай талбайд овоолж, шимт хөрсийг хамгаалсан	0	20	
<b>Газрын хэвлийн ашиглалт</b>					
52	ГХТХ 20.1	Газрын хэвлийг олгосон зориулалтын дагуу ашигладаг	0	20	-
53	ГХТХ 20.2.3	Газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хорт нөлөөнөөс байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, тусгай хамгаалалттай газар байгалийн болон түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг хангаж ажилладаг	0	5	

54	ГХТХ 20.2.4	Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар зөсөж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэж өгсөн	0	5	
<b>Дотоод хяналт шалгалт</b>					
55	ТХШТХ-ийн 7.2, АТХ 7.1.4, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоол	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг	0	5	5
56		Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг	0	5	5
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>396</b>	<b>0</b>

191 45

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж байгууллагын эрх бүхий албан тушаалтан
<i>Б. Ганзориг</i> <small>/овог, нэр/</small>	<i>Б. Ганзориг</i> <small>/овог, нэр/</small>	<i>Д. Могоосбаатар</i> <small>/овог, нэр/</small>
<i>Б. Ганзориг</i> <small>/гаарын үсэг, тэмдэг/</small>	<i>Б. Ганзориг</i> <small>/гаарын үсэг, тэмдэг/</small>	<i>Д. Могоосбаатар</i> <small>/гаарын үсэг, тэмдэг/</small>

Тайлбар: 191 - 45

24% Ганзориг

**Хөрөнгө оруулалт, засаж сайжруулсан зүйлс:**

2018 оны эхнээс үйлдвэр эхлэхээс өмнө худгаас үйлдвэр хүртлэх ус дамжих шугам уян хоолой байсныг ган хоолой болгон өөрчилж угсралт суурилуулалт хийсэн. Худгийг Монгол улсын хуулийн дагуу гэрчилгээжүүлж, усны тоолуур тавьж, ус ашиглах дүгнэлт, эрхийн бичиг, зөвшөөрөлийг албан ёсоор гаргуулж баталгаажуулсан.



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газартай 2018.07.30-ны өдрийн 11 дугаартай ус ашиглах гэрээг байгуулж, 3 жилийн хугацаатайгаар гаргуулж авсан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2013 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн  
А-157 тоот тушаалын 2 дугаар хавсралт



## УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар 11

.....-ын  
*Хотын Байгаль орчин газар*  
Байгаль орчны агуулам эрхэлсэн төрийн захиргааны тус байгууллага, сум газрын захиргаа, өмнөд хэсгийн байгаль орчны алба  
гаргасан 2018 оны 06 сарын 11-ны өдрийн 09 дугаартай ус ашиглуулах дүгнэлт,  
*ЦХД-ийн Засаг дарга Д.Зоригийн*  
Сам газрын захиргаа, өмнөд хэсгийн Байгаль орчны алба, сум дүүргийн Засаг дарга  
олгосон 2018 оны 06 сарын 11-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл,  
*ЦХД-ийн Засаг дарга Х.Нанжирваан*  
Сам газрын Захираага аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга. Ус хангамж байгууллага  
2018 оны 07 сарын 30-ны өдөр байгуулсан 11 дугаар бүхий ус  
ашиглах гэрээг үндэслэн *Улаанбаатар* аймаг, нийслэл,  
*Богдотогоо дахь сум* сум, дүүрэг 20-р баг, хорооны  
Аврал, аж ахуйн нэгж, байгууллагын хэл  
нутагт байршилтай, улсын бүртгэлийн 9010001065 тоот гэрчилгээтэй,  
2615134 регистрийн дугаартай "Хант БН Ойл" ХХК-г  
Аврал, аж ахуйн нэгж, байгууллагын хэл  
ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж, 20-р хорооны  
байршилтай усны нөөцөөс хоногт 2,2 шөо метр усыг  
Найрврын ус, газрын доорхи ус  
*Хүндэтгэн үнэмлэх* зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг гурван  
жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгоорно

*ЦХД-ийн Засаг дарга Д.Зоригийн*  
аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалалт  
Байгууллага, өмнөд хэсгийн төрийн захиргаа

2018 оны 07 сарын 31-ны өдөр

Үйлдвэрийн хашаанд байрлах ЦТП цахилгааны дэд станцын трансформатор хэсгийн дээд таг болон тэлэгч резин жийрэгнүүд элэгдэн сэтэрч багагүй хэмжээний трансформаторын тос алдсан байсан тул өндөр хүчдэлийн мэргэжилтэн цахилгаанчаар засвар үйлчилгээний гэрээг хийж, нийт 751'500₮ төгрөгийн зардал гарсан. Цаашид трансформаторт хийсэн тосны чанар муудаж байгаа тул тосыг бүтэн сольж, трансформаторыг угаалгах шаардлагатай байгаа болно.







Үйлдвэрийн тосны түргэн халаагчийн цахилгааны шитний электрон төхөөрөмжүүдийг хөргөх хөргөлт муу байсан тул хуучин хөргөх сэнсийг шинэчилж хүчин чадал ихтэй сэнсээр сольж хаалганд нь суурилуулан зарим халж шатсан утас кабелиудыг сольж монтажлан хэвийн ажиллагаатай болгосон ба үүнд нийт 277'250₮ төгрөгийн зардал гарсан. Шитний электрон төхөөрөмжүүдийн хөргөлт ба шит доторх температурыг хэмжих термометр суурилуулж, ажлын үед хаалгыг хааж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байгаа болно.



Тайлант хугацаанд ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернүүдэд (Kia Rhino) ээлжит урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ЕС зөвшөөрөл, хот дотор явах түр зөвшөөрөл (бүтэн жилээр он дуустал), тээврийн улсын үзлэг, оношилгоо, даатгалд зэрэгт хамруулсан.








Компанид бүртгэлтэй машин техник, тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан тухай бүрт засвар үйлчилгээг хийж ажилласан.  
Оффисын урд мод тарьсан талбайн хэсэгт хашлага хийж, зүлэгжүүлсэн.



2018 оны 08 сарын дундаас үйлдвэрийн дамжлагын түргэн халаагчийн 3-4 тень эвдэрч шатсаныг нөөц үлдсэн тень болон хуучин сэлбэсэн ажилладаг тениүдээр сольж хэвийн ажиллагааг хангасан.



Үйлдвэрийн хашааны хойд хэсэгт байсан овоолгоостой шороог 2'000 кв.м талбайд тараан тэгшилж, резервуар паркийн далангийн нурсан эрэгийг налуулж засах газар шорооны ажлыг 5'500'000₮ төгрөгийн өртөгөөр гэрээлж гүйцэтгүүлсэн.





Үйлдвэрийн зарим тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, тосны бочка, тонны куб цагаан сав зэрэг зарим эд хөрөнгийг хийж, хадгалах цоож цуургатай 10х8х7 м хэмжээтэй битүү сэндвичэн агуулахын барилгыг эхлүүлсэн.



**2018 оны санхүүгийн жилийн тайлангийн үзүүлэлтүүд:**

2018 онд нийт 950,149,642.90 ₮ төгрөгийн орлоготой, 629'251'222₮ өртөгтэй, 2'361'785'903₮ авлагатай, цалин хөлсний зардалд 207 '595 '014 ₮ төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 50'907'245 ₮, засвар үйлчилгээний зардалд 4'658'600₮, бусад зардалд 245'596'131₮ төгрөгийн зардлууд гарсан байна.

Ажилчдад 2'000'000₮, Нийгмийн даатгалын байгууллагад 17'212'439₮, ХХОАТатварт 20'330'307₮, ОАТатварт 5'268'952 ₮, газрын төлбөрт 1'560'240₮, ҮХЭХАТатварт 9'916'911₮, НӨАТатварт 95'048'961₮, аудитын үйлчилгээнд 12'500'000₮, бараа материал худалдан авахад 380'015'950 төгрөг зарцуулсан байна.

**2018 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн хураангуй:**

№	А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ	01 сарын 01	12 сарын 31
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	13,640,999.08	51,945,419.62
2	Дансны авлага	1,313,971,201.00	1,500,438,003.91
3	Бусад авлага	451,194,893.68	509,071,999.0
4	Бараа материал	123,893,540.20	123,568,284.77
5	Урьдчилж төлсөн зардал тооцоо	38,392,003.91	14,024,498.46
6	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,941,092,637.87</b>	<b>2,213,030,758.41</b>
7	Үндсэн хөрөнгө	1,257,356,848.40	1,187,285,930.40
8	Биет бус хөрөнгө		
9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,636,952,132.00	1,636,952,132.00
10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,894,308,980.40</b>	<b>2,824,238,062.40</b>
11	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,835,401,618.27</b>	<b>5,037,268,820.81</b>
12	Дансны өглөг	248,110,776.54	302,633,872.28
13	Цалингийн өглөг	128,362,989.49	129,136,875.43
14	Татварын өр	106,046,015.04	74,007,801.86
15	НДШ-ийн өглөг	3,243,799.65	0.00
16	Бусад богино хугацаат өр төлбөр	110,138,112.00	117,809,055.00
17	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>595,901,692.72</b>	<b>623,587,604.57</b>
18	Хувийн өмч	5,211,895,400.00	5,211,895,400.00
19	Нэмж төлөгдсөн капитал	4,592,503,138.14	4,592,503,138.14
20	Хуримтлагдсан ашиг	-5,564,898,612.59	-5,390,717,321.90
21	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,239,499,925.55</b>	<b>4,413,681,216.24</b>
22	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>4,835,401,618.27</b>	<b>5,037,268,820.81</b>
	<b>Б. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>		
23	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>561,474,727.26</b>	<b>950,149,642.90</b>
24	Борлуулалтын өртөг	420,075,855.14	629,251,222.82
25	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>141,398,872.12</b>	<b>320,898,420.08</b>
26	Хүүгийн орлого	98,495,651.43	1,719,461.78
27	Бусад орлого		
28	Ерөнхий ба удирдлагын зардал	298,840,327.06	282,087,814.78
29	Санхүүгийн зардал		
30	Бусад зардал	-3,607,862,098.32	-4,207,520.96
31	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	-23,276,029.75	156,114,971.65
32	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>-3,690,083,891.53</b>	<b>192,617,518.27</b>
33	Орлогын татварын зардал	9,849,565.36	3,924,070.42
34	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>-3,699,933,456.89</b>	<b>173,081,950.69</b>

**Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл:**

Компани их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

**ТУЗ-ийн хурлын талаар:**

Тайлант хугацаанд компанийн “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 2 удаа биечлэн хуралдаж, 4 удаа санал асуулгаар хуралдсан байна. Үүнд:

1. 2018.02.20-ны өдөр 88,88%-н саналын хуудсаар хуралдаж, 1) 2017 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх, 2) “Шонхор үнэлгээ аудит” ХХК-иар аудит хийлгэх асуудлуудыг хэлэлцээд, “Хай Би Ойл” ХК-ийн санхүүгийн тайлан балансад “Шонхор үнэлгээ аудит” ХХК-иар хийлгэхгүй, дахин сонгох тухай, мөн 2017 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан байна.
2. 2018.03.21-ны өдөр 100%-ийн ирцтэй саналын хуудсаар 1) “Хай Би Ойл” ХК-н 2017 оны санхүүгийн тайланд аудит хийх компанийг сонгох, 2) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай хэлэлцээд, Аудитын ажил үйлчилгээг “Далайван аудит” ХХК-иар хийлгэх гэрээ байгуулах, мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018.04.30-ны өдөр товлон шийдвэрлэсэн.
3. 2018.09.06-ны өдөр ТУЗ-н хурал нь 88,88%-ийн саналаар хуралдаж, 2018.04.30 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээс ТУЗ-ийн даргыг, ТУЗ-н дэргэдэх дэд хороод, тэдгээрийн дарга нарыг, ТУЗ-н нарийн бичгийг томилон ажиллуулах шийдвэрийг гаргасан.
4. 2018.10.12-ны өдөр ...%-ийн ирцтэй биечлэн хуралдаж, “Шарын гол” ХК-ийн “Хай Би Ойл” ХК-д өгөх өрийг хувьцаанд хөрвүүлэх талаар хэлэлцэж дийлэнх олонхын санал аваагүй тул тус асуудлыг 7 хоногийн хугацаанд тодруулах Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Мянганбаяр нарын 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж ТУЗ-ын хурлын дахин хуралдуулах тухай шийдвэрлэсэн.
5. 2018.10.29-ны өдөр 100%-ийн ирцтэй, биечлэн хуралдаж, 1) “Шарын гол” ХК-ийн өрийг хувьцаанд хөрвүүлэх тухай, 2) Firebird Mongol Holding A.S.A.R.L байгууллагын санал шаардлагыг хүлээн авах тухай асуудлуудыг тус бүр хэлэлцэж, “Шарын гол” ХК-ийн өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудал дэмжээгүй тул албан бичгээр хариуг мэдэгдсэн. Firebird Mongol Holding A.S.A.R.L байгууллагын “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, ТУЗ-н гишүүдийг шинээр сонгох тухай” асуудал 100% дэмжигдсэнээр “Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018.12.10-ны өдрийн 10.00 цагт “Баянгол ресторан”-нд зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн байна.
6. 2018.12.20-ны өдөр 88,88%-н ирцтэй саналын хуудсаар хуралдаж, 2018.12.10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар томилогдсон ТУЗ-ийн гишүүдээс ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг, ТУЗ-н нарийн бичгийг томилж, “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ө.Хүдрээг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Ш.Амар-Отгоныг томилох, үүнтэй уялдан Гүйцэтгэх захирлын ажлыг хүлээлцэх комисс томилох зэрэг тогтоол шийдвэрүүдийг гаргасан байна.



Эдгээр ТУЗ-н хурлаас гарсан тогтоол шийдвэрүүдийг тухай бүр хуулбарлан МСЗХороо болон “МХБ” ТӨХК-д хүргүүлж байсан байна.

**”Хай Би Ойл” ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:**

“Хай Би Ойл” ХК нь тайлант хугацаанд нийт хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудыг товлон зохион байгуулж, хуралдуулсан байна.

**1) 2018 оны 04 сарын 30-ны өдрийн** Даваа гаригийн 14:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “Баянгол” зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2018 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2018 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

**2) 2018 оны 12 сарын 10-ны өдрийн** Даваа гаригийн 10:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг “Баянгол” зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Монголын Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудаснуудад тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

**Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:**

Компани нь нийт 52’118’954 ширхэг хувьцаатай ба 379 хувьцаа эзэмшигчидтэй байна. Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны	
		Тоо ширхэг	Хувь
1	“БиДиСЕК” ХК	5’455’035	10.47%
2	Firebird Global Master Holdings-2 S.A.R.L	6’779’913	13.01%
3	Firebird Mongol Holdings A S.A.R.L	9’829’928	18.86%
4	“Нью альфа” ХХК	17’327’908	33.25%
5	“Монгол алтан минт” ХХК	4’167’934	8.00%
<b>Дүн</b>			<b>83.59%</b>

/ ҮЦТХТ-өөс 2018.11.19-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

**Удирдлагын талаархи мэдээлэл:**

**2018.04.30** -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Мянганбаяр, Ж.Эрдэмбилэг, Б.Батнайрамдал, Б.Мягмаржав нар, хараат бус гишүүдээр Б.Болормаа, М.Батчулуун, М.Батсүрэн нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Мянганбаяр, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ, ТУЗ-ийн нарийн бичгээр Д.Хандаа нар сонгогдож ажилласан байна.

**2018.12.10** -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Б.Лхагвадорж, Б.Мянганбаяр, Б.Мягмаржав,

А.Батбаяр, С.Ариунбат нар, хараат бус гишүүдээр Т.Тамир, Ц.Батбаяр, А.Харцага нар сонгогдож, ТУЗ-ийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-Отгон, ТУЗ-ийн нарийн бичгийг Д.Хандаа нар гүйцэтгэхээр сонгогдон ажиллаж байна.